



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/266

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай Г

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумдын нийтийн эзэмшлийн талбайд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 84 123 200 /наян дөрвөн сая нэг зуун хорин гурван мянга хоёр зуу/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Гүйцэтгэгчтэй холбогдох хууль журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /А.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль журам, стандартын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал /Б.Өлзийбаяр/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль журмын дагуу 2019 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190292